



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 09/03

Эрдэнэт

Журам батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.15 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих “Эрдэнэт сан”-ийн журмыг хавсралтаар баталсугай.

2.Сангийн эх үүсвэрийг бүрдүүлэн, журамд заасны дагуу зарцуулж, гүйцэтгэлийг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022
оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Ээлжит IX
хуралдааны 09/03 дугаар тогтоолын хавсралт

ЭРДЭНЭТ САНГИЙН ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтууд нь энэхүү журмын зохицуулалтын эрх зүйн үндэслэл болно.

1.2.Орон нутгийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий төсвийн бус хөрөнгөөс бүрдсэн, орон нутгийн хөрөнгийг төлөвлөх, бүрдүүлэх, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тооцох, түүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдөнө.

1.3.Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих, урьдчилан төлөвлөн нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй хүчин зүйлээс шалтгаалан төсвийн жилийн явцад шаардагдаж болзошгүй төсвийн зардлыг нөхөн санхүүжүүлэх, төсвийн бус орлогын эх үүсвэрийг санаачлан бүрдүүлэхэд Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих “Эрдэнэт сан” (цаашид “сан” гэх)-гийн зорилго оршино.

1.4 Орон нутгийн сангийн үйл ажиллагаанд энэхүү журмаас гадна Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

ХОЁР.САНГИЙН ЭХ ҮҮСВЭР

2.1.Сангийн орлого нь дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ:

2.1.1.Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн жилийн үйл ажиллагааны цэвэр ашгийн 20 хүртэл хувь;

2.1.2.Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн бүх төрлийн хандив, тусламж, дэмжлэг;

2.1.3.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компани, аж ахуйн нэгжүүдээс нийгмийн хариуцлагын хүрээнд олгох санхүүжилт, мөнгөн тусламж, хандив

2.1.4.Орон нутагт ашигт малтмал, хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа компани, аж ахуйн нэгжүүдээс гэрээний дагуу олгож буй санхүүгийн дэмжлэг;

2.1.5.Орон нутгийн төрийн байгууллагаас хуулиар хориглоогүй асуудлаар аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлого

2.1.6.Орон нутгийн өмчит байгууллагуудын актлагдсан хөрөнгийг үнэ тогтоон худалдан борлуулсны орлого;

2.1.7.Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн хувьчлалын орлого;

2.1.8.Орон нутгийн төсөвт төлөвлөгдөөгүй, нэр ангилал заагдаагүй бусад

орлого, авлага;

2.2. Сангийн эх үүсвэр нь төрийн сангийн бүртгэлийн дансанд байршина.

2.3. Сангийн орлогын хэмжээг энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нийт дүнгээр нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон батална.

ГУРАВ. САНГИЙН ЗОРИУЛАЛТ, ЗАРЦУУЛАЛТ

3.1. Санг орон нутгийн чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд тухайн орон нутгийн төсвийн бус орлогоос бүрдүүлэх боломж, чадавхыг харгалзан тухайн жилийн төсөвт урьдчилан тусгах боломжгүй, санхүүгийн эх үүсвэр дутмаг байгаа дор дурдсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж, дэмжлэг үзүүлэхэд зарцуулна:

3.1.1. Орон нутгийн үндсэн чиг үүрэгт хамаарах бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын аливаа төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;

3.1.2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан дунд хугацааны хөгжлийн үндсэн чиглэл, хөтөлбөр, бодлого, төлөвлөлтийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх;

3.1.3. Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдлийг даван туулах арга хэмжээг санхүүжүүлэх;

3.1.4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хуульд заасан эрх, үүргийн хэрэгжилтийг хангах шаардлагатай төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;

3.1.6. Төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлыг санхүүжүүлэх;

3.1.7. Төсвийн жилийн дундуур шинээр ашиглалтад орсон барилга, байгууламжийн үйл ажиллагааны болон ашиглалтын зардлыг санхүүжүүлэх;

3.1.8. Урьдчилан тооцох боломжгүй, цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал (төсөвт тусгагдаагүй гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдийг хүлээн авахтай холбогдсон зардал, олон улсын болон улс, орон нутгийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх зардал гэх мэт);

3.1.9. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудаас тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх;

3.1.10. Аймгийн баяр наадам, уул овооны тахилга, тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны зардал;

3.1.11. Тэгш ой тохиож байгаа байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.12. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, цөлжилтийг бууруулах, ойжуулах, энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл,

арга хэмжээний зардал;

3.1.13.Хадлан, тэжээл бэлтгэх иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.1.14.Орон нутагт нэн шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд сургалтын төлбөрийг санхүүжүүлэх, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж, амьдарч байгаа Төрийн албан хаагч болон бусад иргэдэд шаардагдах дэмжлэг, урамшуулах үзүүлэх;

3.1.15.Аймаг, орон нутгийн нэрийг тив, дэлхий, улсын хэмжээнд гаргасан төрийн эрхэм дээд болон хүндэт шагнал хүртсэн иргэдийг шагнах, урамшуулах, хүндэтгэл үзүүлэх;

3.1.16.Түрээсийн болон хямд өртөгтэй орон сууцны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.1.17.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;

3.1.18.Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын цаг үеийн шинж чанартай бусад асуудлыг шийдвэрлэх;

3.1.19.Аймгийн хөгжлийн ирээдүйтэй шууд холбогдсон оюуны хөрөнгө оруулалт хийх, шинжлэх ухааны ололт, шинэ технологи нэвтрүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

ДӨРӨВ. САНГААС ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ

4.1.Сангийн хөрөнгөөр тухайн жилд санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, шаардагдах хөрөнгийн хэмжээний талаарх саналыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь боловсруулж, жил бүрийн 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

4.2.Сангаас хөрөнгө гаргах тухай шийдвэрт заагдсан хөрөнгийн хэмжээ нь тухайн жилийн орон нутгийн төсөвт батлагдсан сангийн нийт дүнгээс хэтрэхгүй байна.

4.3.Сангийн хөрөнгийг энэхүү журмын 3.1-д зааснаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

ТАВ. САНГААС САНХҮҮЖҮҮЛЭХ ХЭМЖЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТООЦОХ

5.1.Сангаас зардал гаргах шаардлага гарсан нөхцөлд төсөл, арга хэмжээг санаачилсан, хариуцан гүйцэтгэх байгууллага, ажилтан нь холбогдох төсөл, төлөвлөгөө, төсвийг зардлын зүйлээр хийсэн дэлгэрэнгүй тооцоог аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэст ирүүлнэ.

5.2.Хэлтэс нь ирүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, журам болон тухайн үеийн зах зээлийн үнэ ханштай нийцэж байгаа эсэх, уг арга хэмжээ, төсөлд сангаас хөрөнгө гаргах зайлшгүй шаардлагатай эсэхийг нягталж, Санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ

5.3.Засаг даргын захирамж болон гэрээ, санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга, түүний эрх олгосон албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн холбогдох мэргэжилтэн зурж, санхүүжилтийг олгоно.

5.4. Санхүүжилтийг уг төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан бүрэн болон хэсэгчлэн олгож болно. Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн онцлогоос шалтгаалан урьдчилгаа олгож болох бөгөөд урьдчилгааны хэмжээ нийт зардлын 50 хувиас хэтрэхгүй.

5.5. Тухайн төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлнэ.

5.6. Төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд Засгийн газрын тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг баримтална.

5.7. Сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь зардлыг зохих шийдвэрт заасан хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд нэмэлт санхүүжилт олгохгүй, харин хэмнэлт гарсан бол төсвийн холбогдох дансанд буцаан төвлөрүүлнэ.

ЗУРГАА.ТАЙЛАГНАЛТ, БҮРТГЭЛ, ХЯНАЛТ

6.1. Сангийн нягтлан бодох бүртгэл тооцооны ажлыг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг төсвийн гүйцэтгэлийн мэдээний маягтаар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах журам, хугацааны дагуу тайлагнана.

6.3. Сангийн хөрөнгөөр бий болсон өмчийг аймгийн Орон нутгийн өмчийн газар нь холбогдох хууль, журмын дагуу тухайн байгууллагын данс, бүртгэлд бүртгүүлэх үүрэг хүлээнэ.

6.4. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлэх үүргийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн холбогдох мэргэжилтэн гүйцэтгэнэ.

6.5. Сангийн зарцуулалтын жилийн эцсийн тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийлгэж, дүгнэлт гаргуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

6.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн үйл ажиллагааг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

6.7. Сангийн гүйцэтгэлд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон энэхүү журамд заасан хяналтын зөвлөл хяналт тавина.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

7.1. Сангаас олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

7.2. Зориулалт бусаар зарцуулсан тохиолдолд тухайн байгууллага төсөвт байгууллага бол батлагдсан төсвөөс нь суутган тооцож, аж ахуйн байгууллага бол

тухайн байгууллагын харилцах данснаас үл маргалдах журмаар нөхөн төлүүлэх асуудлыг ажил гүйцэтгэгч, захиалагч байгууллагын хоорондын гэрээ, хэлцэлд тусган хэрэгжүүлнэ.

7.3. Сангаас эх үүсвэрийг нь гарган санхүүжүүлж байгаа арга хэмжээ, төслийг хэрэгжүүлэхдээ бараа, материал, ажил, үйлчилгээг тухайн үеийн зах зээлийн үнэ, ханшаас дээгүүр бэлтгэсэн буюу гүйцэтгэсэн, хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, үр ашиггүй зардал гаргасан зэргээр хөрөнгийн ашиглалтад зүй бусаар хандсан тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээг хариуцсан байгууллага, албан тушаалтнаас зохих хууль тогтоомжийн дагуу нэхэмжилж, нөхөн төлүүлнэ. Хэрэв уг асуудал нь авлига, ашиг сонирхлын зөрчил болон эрүүгийн шинжтэй байвал хууль, хяналтын байгууллагад шилжүүлнэ.

7.4. Энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.5. Энэхүү журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.